

## 4. Шар шороон шуурганаас урьдчилан сэргийлэх, хянах загвар төслүүд

### 4.1 Үндэслэл

ШШШ нь Зүүн хойд Азийн бүсийн орнуудын байгаль орчин, эдийн засаг болон нийгэмд ихээхэн хор уршиг учруулдаг юм. Энэ хор уршгийн өртөг нь ШШШ-ны давтамж болон эрсдэлд өртсөн зүйлсийн үнэ өртгөөс хамааралтай байдаг. ШШШ-ны улмаас учирч буй шууд хохирол нь ургац болон мал сүрэг, өнгөн хөрс, эд хөрөнгө, бизнес, аж үйлдвэр, дэд бүтэц, тээвэрт тохиолдож, зам тээврийн осол гарч, сургууль болон үйлчилгээ хаагддаг. Шууд бусаар ШШШ нь эмнэлгийн зардал нэмэгдүүлж, хүн амын эрүүл мэндэд нөлөө үзүүлж, орон сууцны болон албан ажлын байшин барилгыг цэвэрлэж, засварлаж, сэргээх зардал шаардаж, машин тоног төхөөрөмжийг элэгдүүлдэг. Хятадын судлаачдын<sup>1</sup> тооцоолсноор тус улсын хөрсний элэгдлийн зардал л гэхэд жил тутам 6,7 тэрбум ам.доллар болдог бөгөөд үүний улмаас учирдаг шууд бус зардал нь даруй 4,5 дахин байдаг ажээ. Зөвхөн БНХАУ дахь ШШШ-тай холбоотой хохирлын хэмжээ жил бүр 70-239 сая ам.доллар болдог байна.

ШШШ-ны учруулж буй асар их хохирол, ШШШ-ны хүч, давтамжийг багасгах яаралтай шаардлагын улмаас түүнээс урьдчилан сэргийлэх, хянах үйл ажиллагааны ач холбогдол тодорхой харагдаж байгаа юм. ШШШ-ны эсрэг хүчин чармайлтын үр дүнд эдийн засгийн хохирол буурч, алдагдсан экосистем нөхөгдөх юм. Хамгийн гол нь ШШШ-ны эх үүсвэр болон замын нутгуудын сая сая хүмүүсийн амьдралын түвшин сайжирч, шуурганд өртдөг бүхий л нутгийн нийгмийн эрүүл мэнд болон аюулгүй байдал сайжрах нь хамгаас чухал билээ. ШШШ-ны улмаас хүний эрүүл мэндэд учирч буй хохирол нь ШШШ-ны эх үүсвэр нутаг болон салхины дагуух бүх газрын хувьд ноцтой асуудал бөгөөд хотожсон төв газруудын хүн амын нягтрал асар өндөр байдгаас ШШШ-тай холбоотой эрүүл мэндийн асуудал ихэд санаа зовоодог юм.

### 4.2 Авсан сургамжууд

Монгол Улс болон БНХАУ хоёулаа Цөлжилттэй тэмцэх үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр боловсруулсан. Улс төрийн хувьд хүлээсэн үүрэг, цөлжилтийн хяналтанд зориулан хоёр орны засгийн газруудын төсвөөс гаргадаг хөрөнгө нэмэгдсэн болон олон улсын донор байгууллагуудаас техникийн болон санхүүгийн туслалцаа үзүүлсэн зэргийн үр дүнд зарим сайн туршлага болон цөлжилтийг багасгах арга хандлагууд тодорхой болж, үүний зэрэгцээ зарим сургамж ч авсан юм. Эдгээр нь:

- ШШШ бол зөвхөн нэг шалтгаантай бус бөгөөд хил хязгаар дамнан байгаль орчны ноцтой асуудал бөгөөд иймээс бүс нутгийн хамтын хүчин чармайлт шаардана гэдгийг ойлгосон юм. Түүнчлэн, бүс нутгийн харилцан уялдаа холбоотой хүчин чармайлтын зэрэгцээгээр үндэсний санаачлагууд ч мөн зэрэг явагдах нь ач холбогдолтой билээ.
- ШШШ-ны эсрэг авч буй арга хэмжээнүүдийн далайц нь түүний эх үүсвэр нутгийн хэмжээтэй уялдахуйц байх нь чухал.
- Цөлжилттэй тэмцэхдээ хэд хэдэн салбарыг хамарсан арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь илүү үр дүнд хүргэх юм. Үүний зэрэгцээгээр, ганцхан үйл ажиллагаа (тухайлбал мод тарих мэт) хэрэгжүүлэх нь ШШШ-ны асуудлыг шийдвэрлэж чадахгүй билээ.
- Холбогдох бүх талууд (ялангуяа эх үүсвэр газрууд дахь нутгийн оршин суугчид) ШШШ-ыг бууруулах талаар хамтран ажиллах нь маш чухал юм. Төв засгийн газар, орон нутгийн захиргаа болон нутгийн оршин суугчдын үүрэг хариуцлага янз бүр юм. Өргөн уудам нутгийг хамруулан харьцангуй боломжийн зардлаар хэрэгжүүлж болох арга хэмжээний багцыг боловсруулах бололцоотой.

<sup>1</sup> Лу Чи болон Ву Бо нар, Хятад дахь Хүн ам, Нөөц, Байгаль орчин 2002, 12 – 2: 29-33

### 4.3 Загвар төслүүдийн хөрөнгө оруулалтын стратеги

Хөрсний элэгдлийг хянах, байгаль орчныг хамгаалах, тогтвортой хөгжлийг хангах олон улсын, бүс нутгийн болон үндэсний эрх ашиг, сонирхлыг харгалзан үзэж ШШШ-наас урьдчилан сэргийлэх, хянах хөрөнгө оруулалтын стратегийг санал болгож байна. Энэхүү стратеги нь Зүүн хойд Азийн байгаль орчны, эдийн засгийн, нийгмийн тогтвортой хөгжлийг өргөн утгаар нь хамгаалахыг зорьж байгаа ба ШШШ-ны эх үүсвэр болон замын дагуух нутаг, түүнд өртөж буй салхины доод талын нутгууд дахь хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдал, хамгаалалыг сайжруулахад чиглэж байгаа болно. Хөрөнгө оруулалтын стратегийн зорилго, тэргүүлэх чиглэл, хамрах хүрээг тодорхойлон санал болгохдоо дараах зүйлсийг харгалзан үзсэн болно. Эдгээр нь:

- Хэрэгжих боломж
- Өртөг зардлын хэмжээ
- Тогтвортой байдал
- Шинэ арга хандлага болон арга зүй
- Бодлогын болон бүтцийн хувьд үргэлжлэх санаачлагууд

болно.

БНХАУ болон Монгол Улсын байдал ямар нэгэн байдлаар ялгаатай юм. Тийм ч учраас улс тус бүрийн хувьд стратегийн хөрөнгө оруулалтын бүрэлдэхүүн хэсэг нь нэлээд өөр байх ажээ. БНХАУ нь ОП12-ын дагуу АХБ болон ДДБОС-гийн түнш билээ. Ирэх 10 жилийн хугацаанд хөрсний элэгдэлтэй тэмцэх, ядуурлыг бууруулахад чиглэсэн төслүүдэд 1,5 тэрбум ам.доллар зарцуулагдана. Эдгээр хүчин чармайлтын зорилго нь ШШШ-наас урьдчилан сэргийлэх, хянахад чиглэсэн арга хэмжээний зорилготой харилцан бие биеэ нөхөж байгаа юм. Тиймээс ч БНХАУ ШШШ-наас урьдчилан сэргийлэх, хянах үйл ажиллагаа, арга хэмжээнүүдийг үнэлэх хөтөлбөрөө ДДБОС-гийн ОП12-ын хүрээнд боловсрогдож буй төслүүдтэй тааруулан, өөрчлөх ёстой болж байгаа юм. Үүний зэрэгцээ нэгэнт хил хязгаар дамнасан асуудал болохын хувьд хоёр талын хамтарсан хөтөлбөр, түншлэлийг олон улсын харилцаа болгон өргөжүүлэх шаардлага гарч байгаа билээ.

Хөрөнгө оруулалтын стратегийн хүрээнд хийгдэх үйл ажиллагаа, авагдах арга хэмжээ нь ШШШ-ны эх үүсвэр нутгийн хэмжээ, ШШШ-нд өртөж буй зүйлсийн нийт үнэлгээ, үнэ цэнэтэй дүйцэхүйц далайцтай байх учиртай. Үндэсний болон орон нутгийн түвшинд хэрэгжих арга хэмжээний багцыг боловсруулахдаа дараахь зүйлсийг анхаарах ёстой. Эдгээр нь

- Засаг захиргааны нэгжийн нийт нутаг дэвсгэрт хамаарах, үндэсний болон аймаг, мужийн түвшинд тодорхой үйл ажиллагаа шаардах захиргааны болон бодлогын арга хэмжээнүүд
- Тодорхой нутгаар хязгаарлагдах арга хэмжээнүүд юм.

Эхний ангилалд багтах үйл ажиллагааны тоонд хөрсний элэгдлийн шалтгаан болсон дарамтуудыг арилгахад чиглэсэн хууль эрх зүйн, бодлогын болон захиргааны бичиг баримт, дүрэм журмыг хянаж үзэх, бэлчээрийг хаших, хэрэглээнээс түр гаргах замаар доройтсон нутгийг эргэн сэргээж ургамалжуулах техник арга хэмжээ авах, чадавхи бий болгох, сургалт хийх, өргөтгөсөн үйлчилгээг үзүүлэх зэрэг багтана. ШШШ-ыг бууруулахад олон техник арга хандлагууд үр дүнтэй нь харагдсан хэдий ч тэдгээрийг зөв зохистой оновчтой хослуулах нь чухал юм. Харин хоёр дахь ангилалын арга хэмжээнүүд нь зарим тохиолдолд экологийн янз бүрийн нөхцөлд хэрэглэж болохоор байх боловч ерөнхийдөө тухайн газар нутагт таарсан өвөрмөц шинжтэй байх юм.

### 1.1.1 Загвар төсөл хэрэгжих газруудын сонголт

ШШШ-ны эх үүсвэр нутгуудад тодорхойлсон антропогенийн хүчин зүйлсийг шийдвэрлэхдээ эхэн үедээ анхаарлаа тодорхой нутгуудад чиглүүлж, өртөг зардлын хувьд бага байлгах үүднээс загвар төсөл хэрэгжүүлэх аргыг сонгосон болно. Загвар төсөл хэрэгжүүлэхээр сонгож авсан нь дараах гурван үндэслэлээс шалтгаалсан юм. Нэгдүгээрт, төслүүд нь засгийн газрын үүрэгтэй шууд холбоотой бөгөөд иймээс ч одоогийн байгаа болон гарч ирж буй тэргүүлэх чиглэл, ач холбогдолоос шалтгаалан өөрчлөгдөх, нөгөөтэйгүүр нийгмийн эрүүл мэнд, аюулгүй байдал зэрэг холбогдох бусад асуудлуудын хариулт болж болох юм. Хоёрдугаарт, тэдгээрийг орон нутгийн янз бүрийн нөхцөл байдал, үйл ажиллагааны шаардлагууд, санхүүгийн эх үүсвэр болон хэрэгжүүлэх чадвар зэрэгт нийцүүлэн боловсруулж, өөрчилж болно. Гуравдугаарт, төсөл хэрэгжсэнээр тодорхой цаг хугацааны дотор нэмүү өртөг бий болох, үр дүн гарах боломжтой ба загвар төсөл хэрэгжиж буй нутгууд техник арга хэмжээ тохиромжтой эсэхийг үнэлэх, шинэлэг зүйлийг турших, бүтцийн зохицуулалт хийх, бодлого хэрэгжүүлэх талбар болох юм.

Төсөл хэрэгжих нутгийг сонгож авах нь БНХАУ болон Монгол Улсын засгийн газруудын эрх мэдлийн асуудал юм. Энэхүү сонголтыг хийхэд дараах хүснэгтэнд үзүүлсэн шалгуур үзүүлэлтүүдийг харгалзан үзэх ёстой.

#### Хүснэгт 4.1 Загвар төслийн хэрэгжих газрыг сонгох шалгуур үзүүлэлт

Шалгуур үзүүлэлт	
<b>Ерөнхий</b>	<ul style="list-style-type: none"> <li>▪ Шалгуур үзүүлэлт нь дараагийн төслүүдэд хэрэглэж болохуйц ерөнхий байх учиртай</li> <li>▪ Элэгдэн доройтох үйл явц явагдаж байгаа газар сонгосон нутагт багтсан байх нь гол зарчим болно.</li> <li>▪ Төсөл нь өргөн хүрээтэй, нягт уялдаа холбоотойгоор боловсруулагдсан байх ёстой.</li> <li>▪ Загвар төслүүд нь орон нутгийн захиргаа болон олон нийтийн зүгээс авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаатай нягт холбоотой байх учиртай.</li> <li>▪ Орон нутгийн холбогдох талууд газрыг сонгох, төслийг хэрэгжүүлэх үйл явцад оролцох ёстой. Өөрөөр хэлбэл энэ нь доороосоо дээшээ гэсэн чиглэлтэй байх учиртай.</li> <li>▪ Зөвлөмж болгож буй газрууд нь улс тус бүрийн Үйл ажиллагааны үндэсний хөтөлбөрт багтсан байх ёстой. Эсвэл, санал болгож буй загвар төслүүд нь адил асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн орон нутгийн түвшний төслүүдийн гол хэсгүүдтэй холбоотой байж болно.</li> <li>▪ Газрын менежментийн техникийн болон бодлогын талаарх орон нутгийн түвшний туршлага, ололт амжилтийг загвар төслийг сонгож, боловсруулахад маш үнэ цэнэтэй юм.</li> <li>▪ Эдгээр газрууд нь ШШШ-ны эх үүсвэр буюу замын дагуух нутагт байх ёстой ба гадаадаас хүрч очиход хялбар байх ёстой.</li> <li>▪ Загвар төслийн нутаг нь байгалийн янз бүрийн нөхцөл байдлыг багтаасан байх нь зүйтэй.</li> </ul>
<b>Нэмэлт</b>	<ul style="list-style-type: none"> <li>▪ Хөрсний элэгдэл доройтол нь нэлээд хэмжээтэй ба анхны ургамалжилтын байдлыг нь тогтоох боломжийг эрдэмтдэд олгохуйц хэмжээнд зохих үзүүлэлтүүдийн дагуу тооцоолох бололцоотой байх ёстой.</li> <li>▪ Хөрсний элэгдэл доройтол нь хүний үйл ажиллагаанаас болсон байх ёстой.</li> <li>▪ Хөрсний элэгдэл доройтол нь ШШШ нэмэгдэхэд нөлөөлж байх ёстой.</li> <li>▪ ШШШ-ны эсрэг авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийн үр дүнг үнэлэхэд чиглэсэн хяналт шинжилгээ хийх боломжтой байх ёстой.</li> </ul>
<b>Тусгай</b>	<p><b>Хамрах хүрээ</b></p> <ul style="list-style-type: none"> <li>▪ Төслийн хэрэгжих нутгийн хэмжээ нь ерөнхийдөө 10,000 га-гаас дээш дээш байх ёстой.</li> <li>▪ Турших, үзүүлэх бүрэлдэхүүн хэсгүүд нь тухайн нутагт хамаарах өвөрмөц байна.</li> <li>▪ Анхаарал хандуулах нутаг нь газрын янз бүрийн хэлбэр, төрөл, хэрэглээг багтаана.</li> <li>▪ Үргэлжлэх хугацаа нь дор хаяж 5 жил байна.</li> </ul> <p><b>Зорилго</b></p> <ul style="list-style-type: none"> <li>▪ Байгаль орчны</li> <li>▪ Эдийн засгийн</li> <li>▪ Нийгмийн</li> <li>▪ Хуулан хэрэгжүүлэх боломжтой</li> <li>▪ Ядуурлыг бууруулахад хувь нэмэр оруулсан</li> </ul> <p><b>Амьжиргааны байдал</b></p> <ul style="list-style-type: none"> <li>▪ Амьжиргааны байдлын сонголтыг (газрыг үргэлжлүүлэн хэрэглэсэн, хэрэглэхээ болисон, нутгийн хүмүүсийн амьжиргааны байдал өөрчлөгдсөн, нүүн суурьшсан гэх мэт) тодорхойлох</li> </ul> <p><b>Газрын хэрэглээ</b></p> <ul style="list-style-type: none"> <li>▪ Тариалангийн газар: 2-4-р сарын хооронд газрыг ашиглалтгүй байлгах аас зайлсхийсэн аргыг сонгох</li> <li>▪ Бэлчээрийн газар: Бэлчээрийн даац хэтрүүлэхээс сэргийлсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх</li> <li>▪ Тусгай хамгаалалттай нутаг: Хаших, ургамалжуулах, ургамалын төрлийг сонгох зэргийг харгалзан үзэх</li> </ul>

Шалгуур үзүүлэлт	
Тусгай	<p><b>Усны нөөц</b></p> <ul style="list-style-type: none"> <li>▪ Байгаа усны нөөцийг тооцоолох, хязгаарлагдмал нөөцийн хуваарилалт</li> <li>▪ Усны зохистой түвшинг тодорхойлох</li> <li>▪ Хөрсний усыг хэт их хэрэглэхийн эсрэг хяналтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх</li> </ul> <p><b>Үр дүнг тооцоолох</b></p> <ul style="list-style-type: none"> <li>▪ ШШШ-ны эсрэг арга хэмжээнүүдийн үр дүн тоос шороо зэрэг үзүүлэлтүүдэд тоон байдлаар яаж нөлөөлж буйг үзэх</li> <li>▪ ШШШ-ны эсрэг арга хэмжээнүүдийн үр дүн тоос шороо зэрэг симуляцийн загварын үзүүлэлтүүдэд яаж нөлөөлж буйг үзэх</li> </ul> <p><b>Загвар төслийн үнэлгээ</b></p> <ul style="list-style-type: none"> <li>▪ ШШШ-ны үндсэн мэдээллийн хяналтын зүйл болон арга зүйг тодорхойлох</li> <li>▪ ШШШ-ыг бууруулсан хэмжээний болон өдөр тутмын үйл ажиллагааны хяналтын энгийн аргыг боловсруулсан байдлын нарийвчилсан үнэлгээ шаардлагатай.</li> <li>▪ Энгийн аргыг ашиглан ШШШ-ны бууралтын байдлыг үнэлэх урт хугацааны хяналт шаардлагатай.</li> </ul>

БНХАУ болон Монгол Улсын Засгийн газрууд өөрсдийн нутаг дэвсгэр дээр тус бүр дөрвөн газрыг сонгосон ба хил дамнансан нэг нутгийг мөн нэмж сонгосон болно. Эдгээр нь бүгд ШШШ-ны эх үүсвэр нутаг ба ШШШ-ны замын дагуу байршилтай бөгөөд байгалийн болон хүний хүчин зүйлсийн нөлөөгөөр экологийн хувьд доройтсон байгаа юм. Сонгож авсан газруудын биофизикийн, экологийн, болон нийгэм эдийн засгийн байдлыг энэхүү тайлангийн гуравдугаар боть болох *Загвар таслаар дамжуулан Шар шороон шуурганаас урьдчилан сэргийлэх болон бууруулах х<sup>р</sup>н<sup>о</sup> оруулалтын стратеги*-д тайлбарласан болно. Эдгээр газруудыг сонгохдоо янз бүрийн экосистемийн төлөөлөл болох, газрын хэрэглээ, хүн амын нягтрал, өрхийн амьжиргааны стратегийн төрөл бүрийн хэлбэрийг багтаасан гэсэн байдлаар сонгосон юм. Зарим үйл ажиллагаа, арга хэмжээ нь зөвхөн тухайн сонгосон нутагт тохирсон байхад зарим нь янз бүрийн экосистемд үнэлэгдэж болохоор байгаа юм. Эдгээр арга хэмжээ мөн янз бүрийн түвшинд хэрэгжинэ. Мужийн буюу Монгол улсын хувьд аймгийн түвшинд тухайн засаг захиргааны нэгжийн хувьд бүхэлд нь хамаарах бодлогын болон захиргааны арга хэмжээ байгаа бол зарим үйл ажиллагаа, арга хэмжээ нь тухайн нэг хэсэг газраар хязгаарлагдах нь бий. Зарим газар нь 10,000 га-гаас дээш томоохон нутаг дэвсгэрийг хамарч байхад нар салхины эрчим хүчтэй холбоотой зарим газрын хэмжээ 1 га-гаас ч бага байгаа юм.

#### 4.3.2 БНХАУ-д хэрэгжих загвар төслүүдэд санал болгож буй газрууд

Хэдийгээр ШШШ нь БНХАУ-ын баруун болон умард нутгуудын нэлээд олон газраас гардаг хэдий ч тус улсын Засгийн газар загвар төсөл хэрэгжих нутгуудыг Өвөр Монголын Өөртөө Засах Орны нутгаар хязгаарлахаар шийдсэн юм. Загвар төсөлд сонгосон дөрвөн газар болох Алашаа, Ордос, Шилийн гол болон Хөлөнбуйр нь байгалийн янз бүрийн нөхцөл байдлыг багтаасан баруунаас зүүн тийш 1500 км газрыг хамарсан зурваст оршдог байна. Эдгээр нь дөрвөн чухал экологийн бүс бөгөөд Хөлөнбуйр уулын нуга, Шилийн гол нь ердийн, Ордос хуурай, харин Алашаа нь говь цөлийн шинжтэй юм. Эдгээр нь бүгд элэгдэж доройтсон нутгууд бөгөөд харин цагаа олж зохих арга хэмжээ авбал сэрэгэх боломжтой байна. Баруун талын Алашаа нь жилийн хур тунадас 40-200 мм байдаг хуурай бол энэ үзүүлэлт 190-300 мм байдаг Ордост Шар мөрний хөвөөг дагасан элсэрхэг нутгаас гадна цөл болон шар шороот толгодын захын элсэрхэг тал ордог. Шилийн голд (хур тунадас 350 мм-ээс дээш) бол элсэн давхаргын дор шар шороот хөрс бий. Хөлөнбуйрт хур тунадас 300 мм-ээс давдаг ба хөрс нь элсэн давхаргатай. Зураг 4.1-д БНХАУ-ын эдгээр нутгуудын байршил болон хил дамнансан гаүцзрын байршлыг харууллаа.


#### 4.3.3 Монгол улсад хэрэгжих загвар төслүүдэд санал болгож буй газрууд

Засгийн газрын төлөөлөгчид, судалгааны байгууллагын эрдэмтэдтэй уулзаж ярилцан, газар дээр нь очиж үзсэний үндсэн дээр Монгол улсад төсөл хэрэгжих дөрвөн газрыг

#### 4- Шар шороон шуурганаас урьдчилан сэргийлэх, хянах загвар төслүүд 4-5

сонгосон болно. Эдгээр газар тус бүр нь хэд хэдэн сумын нутгийг хамарч бодит болон хүний нөөцийг нэлээд хэмжээгээр багтаажээ. Байршил, засаг захиргааны нэгжүүдийн хил, ШШШ-тай холбоотой зарим мэдээллийг Зураг 4.2-т үзүүлээ.


**Зураг 4.1 БНХАУ-ын Өвөр Монголд хэрэгжих загвар төслүүдийн газруудын зураг**



**Тайлбар:**

- БНХАУ-ын сонгож авсан 4 газар нь баруунаас зүүн тийш Алашаа, Ордос, Шилийн гол, Хөлөнбуйр болно.
- Хил дамнансан газрын БНХАУ-ын талын нутаг нь Эрээн хот юм.

**Зураг 4.2 Монголд хэрэгжих загвар төслүүдийн газруудын зураг болон ШШШ-ны зам**



### 3.4 Санал болгож буй хил дамнансан газар

Хил дамнансан загвар төсөлд санал болгож буй газар бол БНХАУ-ын Эрээн хот, Монгол Улсын Замын Үүд хотыг хамарсан хил орчмын газар юм. Замын Үүд нь Дорноговь аймагт байрладаг ба 12,900 хавтгай дөрвөлжин километр газрыг хамарсан нэг сум юм. Цаг уурын хувьд зэргэлдээ орших Эрээн хотын адил хатуу ширүүн нөхцөлтэй энэ хоёр газарт гадаргын ба хөрсөн доорх усны гачигдал нүүрлэдэг. Газарзүйн байршил, цаг уурын бэрхшээл, байгалийн нөөц ерөнхийдөө байхгүй зэрэг бэрхшээлийг хилийн хоёр талд оршин суудаг хүмүүс өөр өөр аргаар шийдэж ирсэн байна.

БНХАУ-д янз бүрийн арга хэмжээг хослуулан хэрэгжүүлэх замаар байгаль орчныг хамгаалахад анхаарч иржээ. Хотын төвөөс 10 км-ын радиус дотор мал бэлчээрлүүлэхийг хориглох, салхины болон бусад хамгаалалт болгон мод тарих, бохир усыг шинэлэг аргаар ашиглах зэрэг нь хэрэгжүүлж буй арга хэмжээний нэгээхэн хэсэг юм. БНХАУ-ын талын авсан сургамж, боловсронгуй болгон хэрэглэсэн арга туршлагыг Монголын тал ашиглах боломж бий болгохын тулд технологи шилжүүлэх ажил хийгдэх бололцоотой.

Энэхүү төсөлд түнш дөрвөн орны мэргэжилтнүүд оролцох шаардлагатай байгаа нь тодорхой байна. Энэхүү хил дамнансан газар нь янз бүрийн холбогдох оролцогч талуудын хувьд санаа бодол, арга хандлагуудаа турших бололцоо олгох юм. Түнш дөрвөн орны техникийн нөү-хау солилцоонд дэмжлэг үзүүлэх зорилгоор сургалтын төв ч байгуулах ёстой байна. Үүний зэрэгцээ, ургамал хамгаалах, үржүүлэх өндөр технологийн төв ч байх хэрэгтэй. Амьжиргааны сонголтыг нэмэгдүүлэх зорилгоор Монголын талын Говийн бүс нутагт байгаль хамгаалах хатуу журам бүхий экотуризмыг хөгжүүлэхэд анхаарал хандуулахыг Монгол улс зөвлөмж болгосон болно.

### 4.4 Санал болгож буй үйл ажиллагаа болон Хөрөнгө оруулалтын шаардлагууд

#### 4.4.1 БНХАУ-ын сонгосон газруудад хэрэгжих төслийн үйл ажиллагаа

Хүснэгт 4.2 нь БНХАУ дахь төслийн газруудад хэрэгжүүлэхээр санал болгож буй үйл ажиллагаа, арга хэмжээг хураангуйлан үзүүллээ.

Items		Sites	Алашаа	Ордос	Шилийн гол	Хөлөнбуйр
ШШШ-наас урьдчилан сэргийлэх, хянахын тулд хөрсний элэгдэл доройтолтой тэмцэх	Урьдчилан сэргийлэх	Тариалангийн талбайг ой, бэлчээр болгох			Хамгаалалтын арга хэмжээг баримтжуулах	
	Сэргээх	Орон нутгийн тулгуур үйл ажиллагааны менежмент	<ul style="list-style-type: none"> <li>Үр суулгах</li> <li>Хаших</li> </ul>	Орон нутгийн тулгуур үйл ажиллагааны менежмент	<ul style="list-style-type: none"> <li>Орон нутгийн тулгуур үйл ажиллагааны менежмент</li> <li>Хаших</li> </ul>	
	Хөгжүүлэх	<ul style="list-style-type: none"> <li>Говь цөл дээр суурилсан үйлдвэрлэлийн салбар</li> <li>Эрчим хүчний бусад эх үүсвэр</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Говь цөл дээр суурилсан үйлдвэрлэлийн салбар</li> <li>Эко аялал жуулчлал<sup>1</sup></li> </ul>	Таримал бэлчээрийн менежмент	<ul style="list-style-type: none"> <li>Таримал болон байгалийн бэлчээрийн менежмент</li> <li>Эрчим хүчний бусад эх үүсвэр</li> </ul>	
ШШШ-наас урьдчилан сэргийлэх, хянах арга хэмжээг хэрэгжүүлэх чадавхийг бий болгох			<ul style="list-style-type: none"> <li>Бусад чадавхи бий болгох сургалтын төв</li> <li>Орон нутгийн засаг захиргааны чадавхийг бий болгох</li> </ul>	Орон нутгийн засаг захиргааны чадавхийг бий болгох	<ul style="list-style-type: none"> <li>Бусад чадавхи бий болгох сургалтын төв</li> <li>Орон нутгийн засаг захиргааны чадавхийг бий болгох</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Бэлчээрийн менежментийн сургалтын төв</li> <li>Орон нутгийн засаг захиргааны чадавхийг бий болгох</li> </ul>

4- Шар шороон шуурганаас урьдчилан сэргийлэх, хянах загвар төслүүд 4-7

Items	Sites	Алашаа	Ордос	Шилийн гол	Хөлөнбуйр
Газарт үзүүлэх ачаалал, тоосжилтыг багасгахын тулд ядуурлыг бууруулах		Салхи ба нарны эрчим хүч <sup>2</sup>	Тэжээлийн ургамал тариалах сайн туршлагауд	Тэжээлийн ургамал тариалах сайн туршлагауд	<ul style="list-style-type: none"> <li>Тэжээлийн ургамал тариалах сайн туршлагауд</li> <li>Салхи ба нарны эрчим хүч</li> </ul>
Амьжиргааг дээшлүүлж, мал аж ахуй, газар тариалангаас хамаарах хамаарлыг бууруулах, дэд бүтцийг сайжруулах нийгмийн хөгжлийн асуудлууд		Бусад чадварыг хөгжүүлэх		Бусад чадварыг хөгжүүлэх	

<sup>1</sup> Эко аялал жуулчлалыг хөгжүүлэхдээ орон нутгийн байгаль орчны багтаамж чадавхийн хүрээнд нарийн хатуу хяналтын дор зохион байгуулах учиртай

<sup>2</sup> Сэргээгдэх эрчим хүч болон түлшинд хэмнэлттэй бусад аргуудыг нэвтрүүлснээр модлог ургамалын хэрэглээ багасч, тэдгээр нь хөрсний өнгөн давхаргыг тогтворжуулах үүргээ гүйцэтгэх юм.

БНХАУ-ын сонгож авсан нутгуудад хэрэгжүүлэхээр санал болгож буй арга хэмжээ болон төслийн үйл ажиллагаан дээр үндэслэн тооцоолсон өртөг зардал болон хамрагдах хүрээг Хүснэгт 4.3-т үзүүлсэн болно.

**Хүснэгт 4.3 БНХАУ-д хэрэгжих төслийн үйл ажиллагааны өртөг болон хамрах хүрээ**

Төсөл хэрэгжих газар	Үйл ажиллагаа	Өртөг сая ам.доллар	Хамрах хүрээ
Алашаа	Орон нутгийн тулгуур үйл ажиллагааны менежмент	2	50,000 га (сургалт, чадавхи бий болгох, гарын авлага, видео материал, зурагт хуудас хэвлэн гаргах зэрэг багтана)
	Цөл дээр тулгуурласан хувийн хэвшил	1	10,000 га
	Эрчим хүчний бусад эх үүсвэр	5-10	5,000-10,000 га
	Амьжиргааг шинэ чадвар бий болгох сургалт	3	500 хүн (үүсгэн байгуулах, тоног төхөөрөмж, боловсон хүчин багтана)
	Орон нутгийн засаг захиргааны чадавхи бий болгох	1	5 жилийн хугацаанд 100-150 ажилтан
	<b>Нийт</b>	<b>12.0-17.0</b>	
Ордос	Орон нутгийн засаг захиргааны чадавхи бий болгох	1	5 жилийн хугацаанд 100-150 ажилтан
	Цөл дээр тулгуурласан үйлдвэрлэл хөгжүүлэх загвар	20	50,000-100,000 га
	Суулгацын арга техник	1	100,000 га
	Хашаа барих арга техник		
	Зүлэгжүүлэх, бут тарьж суулгах	0.2	2,000 га
	<b>Нийт</b>	<b>22.2</b>	

4-8 4 Шар шороон шуурганаас урьдчилан сэргийлэх, хянах загвар төслүүд

Төсөл хэрэгжих газар	Үйл ажиллагаа	Өртөг сая ам.доллар	Хамрах хүрээ
Шилийн гол	Нутгийг хамгаалах харилцан уялдаа холбоотой багц арга хэмжээ	0.5	25,000 га
	Орон нутгийн засаг захиргааны чадавхи бий болгох	1	5 жилийн хугацаанд 100-150 ажилтан
	Шилжин суурьшсан малчдад зориулсан чадварын сургалт	3	500 хүн
	Зүлэгжүүлэх, бут тарьж суулгах	0.2	2,000 га
	Орон нутгийн тулгуур үйл ажиллагааны менежмент	2	50,000 га (сургалт, чадавхи бий болгох, гарын авлага, видео материал, зурагт хуудас хэвлэн гаргах зэрэг багтана)
	<b>Нийт</b>	<b>6.7</b>	

Хөлөнбуйр	Орон нутгийн тулгуур үйл ажиллагааны менежмент	2	50,000 га (сургалт, чадавхи бий болгох, гарын авлага, видео материал, зурагт хуудас хэвлэн гаргах зэрэг багтана)
	Зүлэгжүүлэх, бут тарьж суулгах	0.2	2,000 га
	Хятадын нарс мод тарьж суулгах	0.5	10,000 га
	Эрчим хүчний бусад эх үүсвэр	10	5,000-10,000 га
	Орон нутгийн засаг захиргааны чадавхи бий болгох	1	5 жилийн хугацаанд 100-150 ажилтан
	Хашаа барих арга техник		
	Олон нийтийн ойлголт, мэдээлийг нэмэгдүүлэх кампанит ажил	2	100,000 га
	<b>Нийт</b>	<b>15.7</b>	

#### 4.4.2 Монгол улс дахь төслийн нутгуудад хэрэгжүүлэх төслийн үйл ажиллагаа

Хүснэгт 4.4-т Монгол улсад төсөл хэрэгжүүлэх нутгуудад саналд болгож буй төслийн үйл ажиллагаа, арга хэмжээний тоймыг үзүүлсэн болно.

#### Хүснэгт 4.4 Монгол улс дахь төслийн нутгуудад хэрэгжүүлэхээр санал болгож буй төслийн үйл ажиллагааны тойм

Items	Sites	Өвөрхангай	Өмнөговь	Сүхбаатар	Дорноговь
ШШШ-наас урьдчилан сэргийлэх, хянахын тулд хөрсний элэгдэл доройтолтой тэмцэх	Урьдчилан сэргийлэх	Мод тарих ургамалжуулах	Сумдын эргэн тойрон дахь элсний нүүдлийг тогтворжуулахын тулд мод тарих	<ul style="list-style-type: none"> <li>Дарьгангын байгалийн цогцолбор газрыг бэхжүүлэх</li> <li>Элсний нүүдлийг тогтворжуулахын тулд мод тарих</li> </ul>	Зам болон төмөр замын дагууд салхины хаалт босгох
	Сэргээх	<ul style="list-style-type: none"> <li>Орон нутгийн тулгуур үйл ажиллагааны менежмент</li> <li>Хаших</li> </ul>	Орон нутгийн тулгуур үйл ажиллагааны менежмент	Орон нутгийн тулгуур үйл ажиллагааны менежмент	Орон нутгийн тулгуур үйл ажиллагааны менежмент
	Хөгжүүлэх	Экологийнхувьд хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх Эрчим хүчний бусад эх үүсвэр	Эрчим хүчний бусад эх үүсвэр		
ШШШ-наас урьдчилан сэргийлэх, хянах арга хэмжээг хэрэгжүүлэх чадавхийг бий болгох		Орон нутгийн засаг захиргааны чадавхийг бий болгох	Орон нутгийн засаг захиргааны чадавхийг бий болгох	<ul style="list-style-type: none"> <li>Орон нутгийн засаг захиргааны чадавхийг бий болгох</li> <li>Олон нийтэд ойлгуулах кампанит ажил</li> </ul>	Орон нутгийн засаг захиргааны чадавхийг бий болгох
Газарт үзүүлэх аяаалал, тоосжилтыг багасгахын тулд ядуурлыг бууруулах		Сэргээгдэх эрчим хүчний хэрэглээ			Байгаль орчинд халгүйгээр ядуурлыг бууруулах төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх
Амьжиргааг дээшлүүлж, мал аж ахуй, газар тариалангаас хамаарах хамаарлыг бууруулах, дэд бүтцийг сайжруулах нийгмийн хөгжлийн асуудлууд			Эрчим хүчний бусад эх үүсвэрийг хөгжүүлэх		Дэд бүтэц болон технологийн хөгжил

Монгол Улсын сонгож авсан нутгуудад хэрэгжүүлэхээр санал болгож буй арга хэмжээ болон төслийн үйл ажиллагаан дээр үндэслэн тооцоолсон өртөг зардал болон хамрагдах хүрээг Хүснэгт 4.5-т үзүүлсэн болно.

### Хүснэгт 4.5 Монгол Улсад хэрэгжих төслийн үйл ажиллагааны өртөг болон хамрах хүрээ

Төсөл хэрэгжих газар	Үйл ажиллагаа	Өртөг сая ам.доллар	Хамрах хүрээ
Өвөрхангай	Байгаль орчинд халгүй технологийг алтны үйлдвэрлэлд хэрэглэх	0.7	Жил тутамд 100,000 га
	Орон нутгийн тулгуур үйл ажиллагааны менежмент	1	100,000 га (сургалт, чадавхи бий болгох, гарын авлага, видео материал, зурагт хуудас хэвлэн гаргах зэрэг багтана)
	Сэргээгдэх эрчим хүчний бусад эх үүсвэрийг ашиглах	1-1.5	Жил тутамд 50 өрх
	Орон нутгийн засаг захиргааны чадавхи бий болгох	1	5 жилийн хугацаанд 100-150 ажилтан
	Тарималжуулах үйл ажиллагаа	0.2	
	<b>Нийт</b>	<b>3.9-4.4</b>	
Өмнөговь	Орон нутгийн тулгуур үйл ажиллагааны менежмент	1	100,000 га (сургалт, чадавхи бий болгох, гарын авлага, видео материал, зурагт хуудас хэвлэн гаргах зэрэг багтана)
	Мод тарьж ургуулах	1	100,000 га
	Сэргээгдэх эрчим хүчний бусад эх үүсвэрийг ашиглах	1-1.5	Жил тутамд 50 өрх
	Орон нутгийн засаг захиргааны чадавхи бий болгох	1	5 жилийн хугацаанд 100-150 ажилтан
	<b>Нийт</b>	<b>4.0-4.5</b>	
Сүхбаатар	Дарьгангын байгалийн цогцолбор газрыг бэхжүүлэх	0.3	Жил тутам 20,000
	Орон нутгийн тулгуур үйл ажиллагааны менежмент	1	100,000 га (сургалт, чадавхи бий болгох, гарын авлага, видео материал, зурагт хуудас хэвлэн гаргах зэрэг багтана)
	Элсний нүүдлийг зогсоохын тулд мод тарьж ургуулах	0.6	50,000 га
	Орон нутгийн засаг захиргааны чадавхи бий болгох	1	5 жилийн хугацаанд 100-150 ажилтан
	Олон нийтийн ойлголтыг бий болгох кампанит ажил	0.5	100,000 га
	<b>Нийт</b>	<b>3.4</b>	Жил тутам 20,000
Дорноговь	Зам болон төмөр замын дагуу салхины хаалт босгох	0.5	Жил тутам 253 га
	Орон нутгийн тулгуур үйл ажиллагааны менежмент	1	100,000 га (сургалт, чадавхи бий болгох, гарын авлага, видео материал, зурагт хуудас хэвлэн гаргах зэрэг багтана)
	Орон нутгийн засаг захиргааны чадавхи бий болгох	1	5 жилийн хугацаанд 100-150 ажилтан
	Ядууралын болон байгаль орчны бодлогыг бэхжүүлэх	1	Сайншанд сумын төв
	<b>Нийт</b>	<b>3.5</b>	

#### 4.4.3 Хил дамнансан нутагт хэрэгжүүлэх төслийн үйл ажиллагаа

Дараах хүснэгтээр хил дамнансан нутагт хэрэгжүүлэхээр санал болгож буй төслийн гол үйл ажиллагааг харуулсан болно.

### Хүснэгт 4.6 Хил дамнасан нутагт хэрэгжүүлэхээр санал болгож буй төслийн үйл ажиллагааны тойм

Items	Sites	Эрээн хот – Замын Үүд
ШШШ-наас урьдчилан сэргийлэх, хянахын тулд хөрсний элэгдэл доройтолтой тэмцэх	Урьдчилан сэргийлэх	Орон нутгийн тулгуур үйл ажиллагааны болон мал аж ахуйн менежмент
	Сэргээх	Ургамалжуулах, мод бут тарих
	Хөгжүүлэх	<ul style="list-style-type: none"> <li>Бохир усыг дахин ашиглах, бохир усыг ашиглан усалгаатайгаар мод тарих загвар</li> <li>Эрчим хүчний бусад эх үүсвэр</li> </ul>
ШШШ-наас урьдчилан сэргийлэх, хянах арга хэмжээг хэрэгжүүлэх чадавхийг бий болгох		Уламжлалт болон өндөр технологийн ургамал үржүүлгийн төв, орон нутгийн засаг захиргааны ажилтнуудын сургалт
Газарт үзүүлэх дарамтыг болон тоосжилтыг багасгахын тулд ядуурлыг бууруулах		Экологийн аялал жуулчлал <sup>1</sup>
Амьжиргааг дээшлүүлж, мал аж ахуй, газар тариалангаас хамаарах хамаарлыг бууруулах, дэд бүтцийг сайжруулах нийгмийн хөгжлийн асуудлууд		Холбогдох бүх талуудын ойлголтыг бий болгох кампанит ажил

<sup>1</sup> Эко аялал жуулчлалыг хөгжүүлэхдээ орон нутгийн байгаль орчны багтаамж чадавхийн хүрээнд нарийн хатуу хяналтын дор зохион байгуулах учиртай.

### Хүснэгт 4.7 Хил дамнасан төслийн газарт хэрэгжүүлэх төслийн үйл ажиллагааны өртөг ба хамрах хүрээ

Төсөл хэрэгжих газар	Үйл ажиллагаа	Өртөг сая ам.доллар	Хамрах хүрээ
Эрээн хот – Замын Үүд	Ургамал үржүүлэх өндөр технологийн төв	0.5	Нутгийн хэмжээ янз бүр, жил тутамд 100 мэргэжилтнийг сургана
	Олон улсын сургалтын төв байгуулах	0.5	Жил тутам 200 мэргэжилтнийг сургана
	Хаягдал усыг ашиглах	0.2	Эрэнхот
	Эрчим хүчний бусад эх үүсвэр	0.6	Жил тутамд орон нутгийн 100 малчин
	Экологийн аялал жуулчлал <sup>1</sup>	1.0	Замын Үүд сумын нутаг дэвсгэр
	Орон нутгийн тулгуур үйл ажиллагаа болон мал аж ахуйн менежмент	2.0	100 өрх
	Салхины хаалт зурвас байгуулах	0.2	500 га
	<b>Нийт</b>		<b>5.0</b>

<sup>1</sup> Хил дамнасан нутаг нь тив хоорондын төмөр замын боомт болохын хувьд Говь цөлийн байдал, малчдын амьдралыг сонирхох гэсэн аялагчдын урсгал нэлээд байдаг нь энэхүү үйл ажиллагааны үндэслэл болж байгаа юм. Энэ эх үүсвэрээс олсон орлого нь бэлчээрийн газарт учруулж буй дарамтыг багасгах боломжтой.

## 4.5 Санхүүжилтийн төлөвлөгөө

Загвар төслүүдийн хэмжээ нь уян хатан байх боломжтой тул байгаа хөрөнгийн хэмжээнд нийцүүлэн засаж өөрчилж болох юм. Төсөл хэрэгжих нутаг тус бүрт 3-22 сая ам.доллар шаардлагатай байгаа ч энэ бүх мөнгөний хувьд нэг удаагийн санхүүжилт хийх боломжгүй билээ. Санал болгож буй төслийн зарим бүрэлдэхүүн хэсгийг тусдаа арга хэмжээ байдлаар санхүүжүүлэх боломжтой бол заримыг нь хувийн хэвшлийн санхүүжилтээр шийдэх бололцоо бий. Төслийн бүрэлдэхүүн хэсгүүдийн дотор олон улсын хандивлагчдын одоогийн хэрэгжүүлж буй тусламжийн хөтөлбөрт илүү нийцэж буй арга хэмжээ ч байгаа нь лавтай. ШШШ-наас урьдчилан сэргийлэх, хянах бүс нутгийн сан байгуулж уг санд оролцогч орнууд, хувийн хэвшлийн байгууллагууд, олон улсын хандивлагчдаас тодорхой хувь нэмэр авч байх боломж байна. Энэ сан нь дараагийн эх үүсвэрийн суурь болохын зэрэгцээ төрийн болон хувийн бусад эх үүсвэрээс хөрөнгө цуглуулах механизм болох юм.

Загвар төсөл бүр өөрийн хөрөнгийн өртөгтэй. Газар бүрийн голлох элемент нь авсан арга хэмжээний үр дүнд ШШШ-ны хүч болон давтамжийн бууралтыг хэмжих хяналтын систем суурилуулах ёстой. Энэ хяналтын систем нь янз бүрийн үнэ өртөгтэй байх боловч тооцоолсон өртгийн дээр 1%-ийг нэмэх байдлаар шийдэж болох юм.

ШШШ-ны хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх хэд хэдэн эх үүсвэр бий. Эдгээр нь:

- **Дотоод эх үүсвэр.** Засгийн газрын янз бүрийн түвшинд байгаль орчны менежментийн зардалд зориулах хөрөнгийг төсвөөс хуваарилсан байдаг ч БНХАУ болон Монгол Улсын хувьд ШШШ-ны асуудалд зориулах хөрөнгө төдийлөн их биш юм. Үүний зэрэгцээ, төсөл хэрэгжих нутгийн дотоодын хувийн хэвшил, оршин суугчид, холбогдох талуудаас зарим эх үүсвэр гарч болох юм.
- **Хоёр талын харилцааны сувгууд.** Япон зэрэг хоёр талын хамтын ажиллагааны хүрээнд хандивлагч орнууд төсөл эхлэхийн өмнөх үйл ажиллагаа, загвар төсөл зэргийг санхүүжүүлдэг. Хоёр талын хамтын ажиллагааны хүрээнд үзүүлж буй иймэрхүү туслалцаа ихэнхдээ буцалтгүй тусламжийн хэлбэртэй байдаг. Төслийн бичиг баримт зохих түвшинд боловсрогдсон эсэх болон бүтцийн хувьд шаардлага хангаж буйг хэрэгжих боломжийн судалгаа, загвар төслөөр дамжуулан баталгаажуулахад хоёр талын хамтын ажиллагааны хүрээнд үзүүлж буй туслалцаа чухал үүрэгтэй байдаг. Хэрэгжих боломжийн судалгаа, загвар төсөл хэрэгжүүлэхэд үзүүлж буй хоёр талын хамтын ажиллагааны хүрээний туслалцаа болон үүнийг залган үргэлжилдэг өргөн хүрээтэй төслийг хэрэгжүүлэхэд үзүүлдэг олон улсын хандивлагчдын санхүүжилт хоёрыг хослуулаагүй бол байгаль орчны хувьд асар чухал ач холбогдолтой олон төслүүд хэрэгжихгүй байсан буюу хамрах хүрээ нь мэдэгдэхүйц бага байх байсан юм.
- **Олон улсын санхүүгийн байгууллагууд.** Хоёр талын хамтын ажиллагааны хүрээнд туслалцаа үзүүлж буй донорруудаас гадна олон улсын хэд хэдэн санхүүгийн байгууллагууд бүс нутаг дахь байгаль орчны төслүүдийг санхүүжүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллаж байгаа билээ. Эдгээрээс хамгийн гол үүрэг гүйцэтгэж байгаа нь Азийн Хөгжлийн Банк, Дэлхийн Банк, Европын Холбоо юм. Монгол Улсын Засгийн газар болон олон улсын санхүүгийн байгууллагуудын хооронд маш сайн харилцаа тогтсон байгаа болно. АХБ болон Дэлхийн Банк зэрэг олон улсын санхүүгийн томоохон байгууллагууд ихэнхдээ томоохон хэмжээний төслүүдийг санхүүжүүлэх урт хугацааны зээл олгодог. Харин Засгийн газрууд гадаад өрөө нэмэгдүүлэхээс болгоомжилдог тул ШШШ-тай тэмцэх зорилгоор зээл авахгүй л болов уу.
- **Даян Дэлхийн Байгаль Орчны Сан.** ДДБОС нь ШШШ-ыг хөрсний элэгдлийн асуудлын нэгээхэн хэсэг гэж үздэг. Гэсэн хэдий ч Монгол Улс ДДБОС-гаас ОП15<sup>2</sup>-ын хүрээнд ямарваа нэгэн санхүүжилт авч байгаагүй учраас энэ удаа хөрөнгө хүссэн асуудлыг нь нааштай шийдвэрлэх найдвар бий. Монгол дахь хөрсний элэгдэл доройтол улам л муу болсоор байгаатай бүгд санал нийлж байгаа. Харин БНХАУ бол ДДБОС-гийн ОП12<sup>3</sup>-ын дагуу Хуурай нутгийн экосистемийн хөрсний элэгдэл хөтөлбөрийн түнш орон болсон билээ.
- **Хувийн хэвшлийнхний оролцоо.** Хувийн хэвшлийг оролцуулах замаар байгаль орчны хөрөнгө оруулалтын нэмэлт эх үүсвэрийг дайчлах бололцоотой гэж үзэж байна. Энэ асуудлыг ШШШ-нд өртдөг болон түүний эх үүсвэр болдог орнуудад ойрын жилүүдэд туршиж үзэх юм. Монгол Улсын Засгийн газар энэ үйл явцыг анхааралтай ажиглаж, олон нийтийн эрх ашгийг бүрэн хангасан байдлаар энэ хамтын ажиллагааны шинэ загвар хэрэгжихэд хувь нэмрээ оруулахыг зорьж байна. ШШШ-наас урьдчилан сэргийлэх, түүнийг багасгахад чиглэсэн хөрөнгө оруулалтын нэмэлт шинэ эх үүсвэрийг дайчлах шаардлага

<sup>2</sup> ДДБОС-гийн Газрын тогтвортой менежментийн үйл ажиллагааны хөтөлбөр. Энэ хөтөлбөрт зохимжтой орчинг бий болгох, бүтцийг бэхжүүлэх, хөрөнгө оруулалт зэрэг багтдаг.

<sup>3</sup> ДДБОС-гийн Харилцан уялдаатай экосистемийн менежментийн үйл ажиллагааны хөтөлбөр.

байгаа нь Засгийн газрууд болон олон улсын санхүүгийн байгууллагуудыг хувийн хэвшил оролцсон хамтын ажиллагааны шинэ хэлбэрийг авч үзэхэд хүргэж байгаа юм. Дүгнэж хэлэхэд, БНХАУ ч, Монгол Улс ч бүс нутаг дахь ШШШ-ны хор уршгийг багасгахад шаардлагатай байгаа хөрөнгө оруулалтын ихээхэн хэмжээний дотоод болон гадаад эх үүсвэрийг дайчлах ёстой болоод байна.

Үе шаттай арга хандлага нь хэрэгжүүлэх илүү бололцоотой учраас, санхүүжилтийн төлөвлөгөө нь үүнтэй маш нарийн нягт холбоотой байх учиртай. Төсөл нь ирэх 10 жилийг хамарсан гурван үе шаттай байна. Хүснэгт 4.6-г үзнэ үү.

#### Хүснэгт 4.6 ШШШ-наас урьдчилан сэргийлэх, хянах хөтөлбөрийн үе шат

Үе шатууд ба санал болгож буй үйл ажиллагаа	Шаардлагатай санхүүжилт (мянган ам.доллар)	Санхүүжилтийн эх үүсвэрүүд <sup>1</sup>
<b>Нэгдүгээр үе шат. 2006-2007</b>		
1. Хэрэгжих боломжийн судалгаа	1,000	ЗГ, ХТХАЭУ, ХХ
2. Чадавхи бий болгох	8,000	
3. Бүтцийг хөгжүүлэх болон бодлогын хүрээ	500	
4. Олон нийтийн ойлголтыг бий болгох	500	
<b>Дүн</b>	<b>10,000</b>	
<b>Хоёрдугаар үе шат. 2008-2010</b>		
1. Загвар төслүүдийн хэрэгжилт (Замын Үүд ба Эрээнхот)	5,000	ДДБОС, ЗГ, ХТХАЭУ, ХХ
2. Хяналт шинжилгээ (тоног төхөөрөмж)	1,600	
<b>Дүн</b>	<b>17,600</b>	
<b>Гуравдугаар үе шат. 2010-2015</b>		
1. Хэрэгжих боломжийн судалгаа болон загвар төслүүдийн сургаж дээр үндэслэн шорооны эх үүсвэр болсон гурван газарт төсөл хэрэгжүүлэх	24,000	ДДБОС, ЗГ, ХТХАЭУ, ХХ
2. Хяналт шинжилгээ (тоног төхөөрөмж)	240	
<b>Дүн</b>	<b>24,240</b>	
<b>Нийт Дүн</b>	<b>40,840</b>	

1 ЗГ-Засгийн газар, ДДБОС-Даян дэлхийн байгаль орчны сан, ХТХАЭХ-Хоёр талын хамтын ажиллагааны эх үүсвэрүүд, ХХ-Хувийн хэвшил

ШШШ-тай тэмцэх бүс нутгийн мастер төлөвлөгөөний хүрээнд арга хэмжээ авсан нутгийг өргөжүүлэх шаардлагатай байгаа юм. ШШШ-ны хүч болон давтамжийг бууруулахад үр нөлөөтэй нь батлагдсан арга хэмжээ, үйл ажиллагааны багцыг ШШШ-ны эх үүсвэр нутгийн хэмжээтэй дүйцэхүйц газар нутгийг хамруулан хэрэгжүүлэх ёстой болох юм.